



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2023/40/НА-СА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он</p>	<p>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ё.Лхагвадулам Утас: 325093 Цахим хаяг: lkhagvadulamyo@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 472

танай _____-ны № _____-т

ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ
АХУЙН УДИРДАХ ГАЗРЫН ДАРГА
Ч.МЭНДБАЯР ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ -ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллага нь тайлант онд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын олон улсын ISO45001:2018 стандартыг шинээр 3 салбар төвд нэвтрүүлэн ажилласан байна.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газрын ажилтнуудыг <https://erp.ulaanbaatar.mn/> -нд нэвтрэх кодыг үүсгэж тухайн ажилтан салбар төвүүдийн дурын байрлалаас ажлын цагийн бүртгэлээ хийх боломжтой болгосон байна.

Өөрийн хөрөнгөөр ус дулаан дамжуулах 3 төвд автомат удирдлагын "Scada" программыг бүрэн нэвтрүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, контракт гэрээний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,162,536,759.66	4,145,731,719.19
1.1.02	Дансны авлага	16,151,733,741.57	17,990,969,283.55
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	1,154,128,780.70	1,184,929,516.80
1.1.04	Бусад авлага	287,186,818.98	300,851,510.30
1.1.06	Бараа материал	1,730,925,246.31	2,620,233,746.19
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,804,952.69	56,746,193.60
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	24,489,316,299.91	26,299,461,969.63
1.2.01	Үндсэн хөрөнгө	149,151,992,273.61	148,768,851,376.50
1.2.02	Биет бус хөрөнгө	1,627,596,285.83	7,481,885,681.61
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	150,779,588,559.44	156,250,737,058.11
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	175,268,904,859.35	182,550,199,027.74
2.1.1.01	Дансны өглөг	12,455,705,551.47	11,103,188,157.73
2.1.1.02	Цалингийн өглөг	2,739,366,095.50	3,180,835,573.60
2.1.1.03	Татварын өр	1,143,762,336.22	1,793,105,485.48
2.1.1.04	НДШ - ийн өглөг	647,075,172.25	475,873,779.62
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	727,918,096.96	2,249,698,085.84
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	672,438,767.61	565,003,899.08
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	18,386,266,020.01	19,367,704,981.35
2.1.2.01	Урт хугацаат зээл	54,330,290,805.11	53,816,995,236.33
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	54,330,290,805.11	53,816,995,236.33
2.2	Өр төлбөрийн нийт дүн	72,716,556,825.12	73,184,700,217.68
2.3.01	Өмч: - төрийн	126,942,821,257.61	141,816,174,586.60
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	81,855,430,811.18	78,209,541,830.50
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	1,588,336,597.00	1,588,336,597.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-107,834,240,631.56	112,248,554,204.04
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-20,461,526,892.96	-8,060,202,553.01
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-87,372,713,738.60	104,188,351,651.03
2.3.11	Эздийн өмчийн дүн	102,552,348,034.23	109,365,498,810.06
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	175,268,904,859.35	182,550,199,027.74

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	өмнөх он	тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	114,098,184,147.85	128,472,070,696.23
02	Борлуулалтын өртөг	124,114,322,910.19	134,786,335,883.65
03	Нийт ашиг(алдагдал)	-10,016,138,762.34	-6,314,265,187.42

04	Түрээсийн орлого	10,258,560.00	10,274,923.64
05	Хүүний орлого	0.00	23,006,641.60
08.1	Орлогын дүн	10,258,560.00	33,281,565.24
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	209,994,956.97	228,872,952.41
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	209,994,956.97	228,872,952.41
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-9,069,715,470.48	516,276,793.03
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	2,386,681.82	-698,590,505.39
17	Бусад ашиг (алдагдал)	-1,178,322,944.99	-1,366,127,074.23
17.1	Олз, гарзын дүн	-10,245,651,733.65	-1,548,440,786.59
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-20,461,526,892.96	-8,058,297,361.18
19	Орлогын татварын зардал		1,905,191.83
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-20,461,526,892.96	-8,060,202,553.01
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-20,461,526,892.96	-8,060,202,553.01

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмч	Хөр-н дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-р үлдэгдэл	126,942,821,257.61	81,855,430,811.18	1,588,336,597.00	-107,834,240,631.71	102,552,348,034.08
2	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	3,645,888,980.68	3,645,888,980.68
3	Залруулсан үлдэгдэл	-	-	-		
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-8,060,202,553.01	-8,060,202,553.00
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	14,873,353,328.99			-	14,873,353,328.99
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	0.00

8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-3,645,888,980.68	-	-	-3,645,888,980.68
9	2023 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	141,816,174,586.60	78,209,541,830.50	1,588,336,597.00	-112,248,554,204.04	109,365,498,810.06

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	249,536,199,502.97	282,290,484,032.31
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	248,449,598,693.46	276,152,797,226.61
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	132,128,710.00	143,757,664.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	954,472,099.51	5,993,929,141.70
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	243,425,545,986.05	277,362,974,016.50
1.2.1	Ажиллагчдад төлсөн	28,903,985,008.01	32,229,171,476.39
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,871,999,903.87	9,653,333,821.56
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	5,678,440,524.59	7,460,685,089.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,648,926,219.20	6,962,136,966.21
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	265,862,700.00	276,622,670.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	9,330,958,526.95	9,820,919,817.72
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	185,725,373,103.43	210,960,104,175.42
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,110,653,516.92	4,927,510,015.81
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	23,017,226.56
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	0.00	23,017,226.56
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	6,203,940,834.55	5,965,457,266.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	6,116,020,834.55	5,965,457,266.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	87,920,000.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-6,203,940,834.55	-5,942,440,039.44
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		1,875,016.84
3.2.5	Бусад		1,875,016.84
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		-1,875,016.84
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-93,287,317.63	-1,016,805,040.47
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,255,824,077.29	5,162,536,759.66
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,162,536,759.66	4,145,731,719.19

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 156,964.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

Мөнгөн гүйлгээний тайланд зардлын ангилал (*үндсэн хөрөнгөө олж бэлтгэх зардлыг илүү тайлагнасан*) буруу бүртгэсэн. Энэ нь НББОУС-39 Санхүүгийн Хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба Хэмжилт болон санхүүгийн тайлангийн толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 441,120.4 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,731.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 318,590.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 120,798.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Бэлэн мөнгөний кассаас 1,731.0 мянган төгрөгийг тансаг хэрэглээний материалд зарцуулсан нь байгууллагын үйл ажиллагааны орлогыг үр ашиггүй зарцуулах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 16.1 *"өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах"* заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь:Төлбөрийн акт тогтоолоо.

3.2 Албан шаардлага

Улсын бүртгэлийн гэрчилгээ дэх үйл ажиллагааны чиглэлд дурдсанаас өөр төрлийн худалдан авалт хийж 159,435.9 мянга, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ бүртгэж 40,395.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 *"Үнэн зөв байх"*, 13 дугаар зүйлийн 13.1 *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно"*, 20 дугаар зүйлийн 20.1.4 *"хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх"* заалтуудыг зөрчиж байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны бүрдэл болсон баримтаар нягтлан бодох бүртгэлийн гүйлгээг хийж байх, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны чиглэлийн дагуу худалдан авалт хийж байх, зөрчлийг арилган хэрэгжилтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

Баярын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх болон ажилчдад баярын арга хэмжээний хөнгөлөлт үзүүлж 118,759.4 мянган төгрөгийн зардал гарган байгууллагын хөрөнгийг үрэлгэн зарцуулсан нь байгууллагын эдийн засгийн үр дүнд сөргөөр нөлөөлөх үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 16.1 “*өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;*” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баяр ёслолын арга хэмжээг хэт өргөн дэлгэр тэмдэглэж байгааг хязгаарлан, байгууллагын үр ашгийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллах, зөрчлийг арилгаж биелэлтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тухайн байгууллагад газар эзэмших гэрчилгээгүй 7,748 кв.м газар байгаа нь үндсэн хөрөнгө данс бүртгэлд дутуу тайлагнагдах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “*Үнэн зөв байх*” заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох эрх бүхий байгууллагад хандан газрыг гэрчилгээжүүлж, данс бүртгэлд тусгах зөвлөмж өглөө.

2.Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын зорилтот түвшний батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй 27,162.4 мянган төгрөгийн зардал гаргасан нь батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхгүй, хэтрүүлэн зарцуулах үр дагаварт хүргэж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйл Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх 16.1 “*өөрт олгогдсон хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;*” заалтыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Нийслэлийн Засаг даргын захирамжаар баталсан, НӨХГ-тай байгуулсан контракт гэрээний дагуу батлагдсан төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн зардал гаргаж байх зөвлөмж өглөө.

3. Авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд үүсээд 1-5 хүртэлх жил болж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудаас авах авлагаас тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй 93,636.5 мянган төгрөгийн авлага байгаа нь найдваргүй авлага бий болох үр дагаварт хүргэж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 *"дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;"* заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай үүссэн авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулан барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өглөө.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Удирдах зөвлөлийн гишүүний гадаад томилолтын зардалд 8,222.8 мянган төгрөг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:"*, 12.1.4 *"хуулиар зөвшөөрөөгүй бусад"*, заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоолоо.

Тайлант онд Монголын залуучуудын холбоо, Барилгын хөгжлийн төвийн шагналын зардалд 4,190.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит этгээдэд дараах зүйлсийг хориглоно. 15.1.3. *"хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;"* заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоолоо.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлан таниулах үйл ажиллагаанд болон нэвтрүүлэг контентын зардалд 50,611.7 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4. *"Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх;"*

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, хэрэгжилтийг ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

Байгууллагын төсвөөс тэмцээн, уралдаанд тайлангийн хурал зохион байгуулахад 150,313.3 мянган төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1. *"Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал"*

санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно:" 12.1.4".хуулиар зөвшөөрөөгүй бусад".заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үйл ажиллагааны орлогыг зөв зохистой зарцуулах зөвлөмж өглөө.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХАТХ хууль, тогтоомжтой холбоотой хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд 24,795.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авахдаа төсөвт өртгийг хуваан шууд худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ хуулийн 10 дугаар зүйл Тендер шалгаруулалтын зохион байгуулалт 10.3."Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөн ажиллах журмыг баримтлах, зөрчлийг давтан гаргахгүй зөвлөмж өглөө

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бэлэн мөнгөний кассаас тансаг хэрэглээний материалд	1	1,731.0	1	1,731.0								
Өмнөх аудитаар зөвлөмж өгсөн зөрчлийг давтан гаргасан	1	199,831.1			1	199,831.1						
Баярын өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, ажилчдад баярын арга хэмжээний хөнгөлөлт үзүүлж байгууллагын хөрөнгийг үрэлгэн зарцуулсан	1	118,759.4			1	118,759.4						
Тухайн байгууллагад газар эзэмших гэрчилгээгүй 7,748 кв.м газар байна	1						1					
Байгууллагын зорилтот түвшний батлагдсан	1	27,162.4					1	27,162.4				

	НИЙТ	1	1			1			
--	-------------	----------	----------	--	--	----------	--	--	--